



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧИМ

2014

АГУУЛГА

Оршил

Бүлэг 1. Компанийн зохистой засаглалын үндэс

Бүлэг 2. Хувьцаа эзэмшигчдийн эрх

Бүлэг 3. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Бүлэг 4. Төлөөлөн удирдах зөвлөл

Бүлэг 5. Гүйцэтгэх удирдлага

Бүлэг 6. Санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал

Бүлэг 7. Дотоод хяналтын систем ба эрсдэлийн удирдлага

Бүлэг 8. Оролцогч талууд

ОРШИЛ

Компанийн засаглалын хөгжил, үр дүнтэй байдал нь эрх зүйн зохицуулалтаас гадна компанийн зохистой засаглалын хэм хэмжээ тухайн нийгэмд өдөршсөн, нийтлэг зан заншил, оролцогчдын мэдлэг чадвар, туршлага болон ухамсрын үвшин хэр өндөр байгаа зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг байна.

Компанийн засаглалын зохистой бүтцийн үндэс суурь нь ил тод байдал, үр ашигтай зах зээл, хууль тогтоомжийг дээдлэх, удирдах, зохицуулах, хэрүүлж эрх мэдлийн үүрэг хариуцлагыг зааглан тогтоохыг хөхүүлэн дэмжихэд оршино.

1999 онд анх баталж, улмаар 2004 онд нэмэлт өөрчлөлт оруулаад байгаа Эдийн засгийн хамтын ажиллагаа, өгжлийн байгууллагаас баталсан “Компанийн засаглалын зарчмууд”-ыг өндөр хөгжилтэй бүх улсууд төдийгүй хөгжиж байгаа ихэнх улс орнууд, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтыг нутагшуулах эрмэлзэлтэй орнууд уг жишиг, зохицуулалтыг жинхэнэ утгаар нь нэвтрүүлэх талаар төрийн бодлогын хэмжээнд анхаарч, ач холбогдол өгч байна.

Энэхүү Монгол Улсын гэх Компанийн засаглалын кодексыг олон улсын хэмжээнд мөрдөж буй нийтлэг зарчим болох Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагаас баталсан “Компанийн засаглалын зарчмууд”, Дэлхийн банкны дэргэд дэх Олон Улсын Санжүүгийн Корпораци зэрэг олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, зөвлөгөө, дэлхийн бусад улс орны туршлага, өөрийн орны онцлог, бодит нөхцөл байдал зэргийг харгалзан компанийн засаглалын бүтцийг эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн чигч шударга байдал, зах зээлд оролцогсдын хувьд чухал үүрэгтэй байх асуудлуудыг харгалзан үзсэний үндсэн дээр боловсруулсан.

Энэхүү кодексыг хувьцаа нь нийтэд өлөтэй арилжаалагддаг, нээлттэй буюу хувьцаат компанид тухайлан зориулж боловсруулсан хягаарлагдмал хариуцлагатай компани болон бусад хуулийн этгээдийн өөрхийд онцлогт тохируулан хэрэглэх боломжтой юм.

Манай улсын компани бүр компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшил болгож улмаар компанийн тогтвортойжил, хөрөнгө оруулалтын таатай нөхцөлийг бүрдүүлэн, эдийн засгийн эргэлтийн хурд, хэр хэмжээ болон өсөлтийг ойрын ирээдүйд бодитой хэмжээгээр нэмэгдүүлэх болно.

---oOo---

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. КОМПАНИЙН ЗОХИСТОЙ ЗАСАГЛАЛЫН ҮНДЭС СУУРЬ

1 дүгээр зүйл. Үндсэн ойлголт

Улс орны эдийн засгийн жөгжлийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг бүхий компанийн үр ашигтай үйл ажиллагаа, зах зээлийн шударга, хариуцлагатай, ил тод бай байдлыг хангахад компанийн засаглал чухал үүрэгтэй болохыг дэлхийн эдийн засгийн хямрал харуулж үнэтэй сургамж боллоо гэж хөгжилтэй орнууд үднэж компанийн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх нь компанийн стратегийн нэг чухал хэсэг гэж үзэж байна.

Үндэсний хууль тогтоогчид, зохицуулагчид компанийн засаглалын зарчмыг боловсруулахдаа тухайн компанийн засаглалын тогтолцоо нь олон улсын хэмжээнд яриа хэлэлцээ хийх болон хамтын ажиллагаа өгжүүлэх, үйл ажиллагааны үр ашгаа нэмэгдүүлэхэд ямар чухал үүрэг гүйцэтгэхийг зохих ёсоор үнэлэх шаардлагатай. Хэрэв тухайн нөхцөлүүдийг харгалзан үзэж чадвал хэт зохицуулалтаас зайлсхийж, хувийн хэвшлийн бизнесийг дэмжиж, хувийн болон олон нийтийн институт дахь ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлаж чадна. Үүний тулд дараах зарчмуудыг баримталж ажиллах нь зохистой:

1.1.Компанийн засаглалын тогтолцоог эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн шударга байдлыг хангах, зах зээлд оролцогсдын урамшуулах үр ашигтай, ил тод зах зээлийг дэмжих асуудлуудыг харгалзан үзсэний үндсэн дээр боловсруулна.

1.2.Компанийн засаглалын зарчмыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх эрх зүйн зохицуулалт болон дүрэм, журмаар тавигдах шаардлага нь хуулийг дээдлэн ил тод хэрэгжүүлэх боломжтой байна.

1.3.Эрх бүхий этгээд хоорондын үүрэг хариуцлагын хуваарилалтыг нийтийн эрх ашигт нийцүүлэн тодорхойлдог байна. Эрх мэдлийг хэрэгжүүлэх боломж, ажлын үнэлгэ э болон хүлээсэн үүрэг, хариуцлага, тайлагнах шаардлагыг өндөржүүлэн олон улсын түвшинд хүргэх шаардлагатай байна.

1.4.Удирдах, зохицуулах болон хэрэгжүүлэх албан тушаалтнууд нь хариуцсан үүргээ мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх эрх мэдэлтэй, шударга байна. Түүнчлэн тэдний гаргаж байгаа шийдвэр нь ойлгомжтой, цагаа олсон, ил тод байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

2 дугаар зүйл. Үндсэн ойлголт

Хувьцаа эзэмшигчдийн эрхийн асуудал нь компанийн засаглалын тогтолцооны нэг чухал үзүүлэлт тул тэдгээрийн эрхээ хэрэгжүүлэх нөхцөлтийг бүрдүүлсэн байна. Хувьцаа эзэмшигч нь оруулсан өрөнгийнхөө хувь хэмжээгээр тухайн компанийн өмчийн тодорхой хувийг эзэмших эрхийг эдэлж мөн тэр хэмжээгээр эрсдэл хүлээдэг. Иймд хувьцаа эзэмшигчид компанийн дүрэмд тусгагдсан онцгой шийдвэрийг гаргахад оролцох болон компанийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг байна. Үүнд дараах эрхүүдийг багтаасан байна.

- компанийн үйл ажиллагаатай холбоотой гаргаж буй шийдвэрийг батлах;
- компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах;
- компанийн ашгаас ногдол ашиг хүртэх;
- компанийн хийж буй хэлцлүүдийг хянах;
- компанийг татан буулгахад үлдсэн хөрөнгөөс хувь хүртэх.

Дээрх эрхийн хүрээнд хувьцаа эзэмшигчид доод тал нь дараах эрхүүдийг эдэлнэ.

1.Ногдол ашиг авах эрх

1.1. Компани хувьцаа эзэмшигчдэд шударга болон тогтмол тараах ногдол ашгийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ.

1.2. Ногдол ашгийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ногдол ашиг тодорхойлох дүрэм, журам ил тод байх нь чухал. Иймд компани санхүү нягтлан бодох бүртгэлийн баримт бичгүүдийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах нөхцөлөөр хангаж үр дүнг улирал болон жилээр мэдээнэ.

1.3. Ногдол ашиг тараах шийдвэр гаргаснаас хойш хамгийн богино хугацааны /2 сараас илүүгүй хугацааны/ дотор тараагдсан байна.

2.Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх

Компанийн төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах үүрэгтэй . Хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа чухал асуудлын талаар шийдвэр гаргахад оролцох эрхээ хэрэгжүүлэх ба хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох зэргээр компанийн засаглалд өнөөлөх нөхцөл бололцоогоор хангагдсан байна.

3.Ижил тэгш санал өгөх эрх

Компани хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хязгаарласан аливаа үйл ажиллагаа явуулахаас зайлсхийх ёстой. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчид компанийг өөрчлөх эсвэл татан буулгах зэрэгтэй холбоотой асуудал эсвэл тэдгээрийн эрхийн хязгаарлалттай холбоотой асуудалд санал өгөх эрхтэй байх ёстой.

4.Сонгох ба сонгогдох эрх

4.1. Компани удирдах дээд шатны төлөөллийг ил тод сонгох журмыг боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан байна. Хувьцаа эзэмшигчдэд нэр дэвшигчдийн талаарх тодорхой мэдээллийг цаг тухайд нь нэгэн зэрэг хүргэж мэдээлсэн байна. Мөн гүйцэтгэх удирдлага болон аудитын хорооны гишүүдийн мэдээлэл багтана.

4.2. Хувьцаа эзэмшигчид нь компанийн төлөөлөн удирдах зөвлөлд сонгогдох нөхцөл боломжоор хангагдсан байна. Компанийн сонгох, сонгогдох үйл ажиллагаа шударга ил тод байдлаар явагдах нөхцөлөөр хангагдсан байна.

5.Мэдээлэл авах эрх

5.1. Компани хувьцаа эзэмшигчид компанийн талаарх мэдээллийг тогтмол болон цаг тухай бүр нэгэн зэрэг шуурхай авах эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Зайлшгүй хүргэх мэдээлэлд компанийн жилийн тайлан, санхүүгийн нөхцөл байдал, компанийн аливаа эрсдэл болон бусад компанийн үйл ажиллагаанд хамгийн чухал гэж үзсэн мэдээллүүд багтана.

5.2. Компанийн удирдлага хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг баталгаажуулсан байна. Компанийн удирдлага доо тал нь жилд нэг удаа хувьцаа эзэмшигчдэд тохиолдолд уг бүртгэлийг мэдээнэ.

5.3. Компани дотоод мэдээлэл эсвэл нууцлалын зэрэглэлийн мэдээллийн талаар холбогдох хууль журамд тусгасан заалтууд зөрчигдөж байгаа эсэхэд тогтмол хяналт тавина.

6.Хувьцааг буцаах худалдан авахыг шаардах эрх

6.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж баталсан хувьцаа эзэмшигчдийн эрх эсвэл компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа асуудалд эсрэг санал өгсөн ба тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож чадаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчид өөрсдийн хувьцааг буцаан худалдан авахыг шаардах эрхтэй байхаар компанийн

дүрэмд тусгасан байна. Дүрэмд ялангуяа дараах асуудлуудыг хэлэлцэх тохиолдолд эсрэг санал өгсөн тохиолдолд гэж нарийвчлан заана:

- компанийг өөрчлөн байгуулах /хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох эсвэл эсрэгээр/;
- компанийн үндсэн үйл ажиллагааг өөрчлөх;
- хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарлах.

6.2.Эргүүлэн худалдан авсан хувьцааг бусад хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагч худалдан авсан тохиолдолд энэ нь саналын болон ногдол ашиг авах эрхгүй байна.

7.Шинээр гаргаж буй хувьцааг давуу эрхээр худалдан авах эрх

Хувьцаа эзэмшигчид компанийн шинээр гаргаж буй хувьцааг нэн тэргүүн ээлжид давуу эрхээр худалдах авах эрхтэй байхаар компанийн дүрэмд тусгана.

8.Компанийн үйл ажиллагааг шалгахыг шаардах эрх

8.1. Компани өөрийн үйл ажиллагааг тогтмол хянах механизмыг бий болгосон байна.

8.2. Компанийн хувьцааны доод тал нь 10 хувийг эзэмшигчид дотоод болон хөндлөнгийн аудит эсвэл бусад 3-дагч аудитаар шалгуулах эрхтэй байх нөхцөлийг хангана.

9.Компанийн татан буулгахад үлдсэн хөрөнгөөс хувь хүртэх эрх

Компанийг татан буулгах үйл ажиллагааны үед хувьцаа эзэмшигчид ижил тэнцүү эрхийг эдэлнэ. Компанийг татан буулгах комисс компанийн өр төлбөрийг төлөөд үлдсэн хөрөнгийг хэрхэн хуваарилах талаар журам гаргах ба хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээнд тохирох хэмжээний хөрөнгийг нарийн нягт хуваарилах үүрэгтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

3.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ

3.1.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд удирдлага байна.

3.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа эзэмшигчдийг дараах боломжуудаар хангана:

- компанийн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад түүнийг хэлэлцэн батлах;
- компанийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах;
- компанийн ашгийг хуваарилахад оролцох;
- компанийн хийж буй гэрээ хэлэлцээрт хяналт тавих.

3.1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх үүрэгтэй ба түүнийг зохицуулсан зохицуулалтыг хувьцаа эзэмшигчдийн өмнөөс өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхийн тулд компанийн эрх зүйн зохицуулалтыг тодорхойлон тогтоож хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан компанийн дүрэмд тодорхойлон тусгана:

- компани үнэт цаас гаргах шийдвэрийг батлах;
- компанийн хөндлөнгийн аудиторыг томилох, холбогдох гэрээг батлах;
- төлөөлөн удирдах өвлөлийн гишүүдийг үнэлэх үнэлгээний системийг хэлэлцэн шийдвэрлэх;
- хуулийн холбоод, олон нийтийн байгууллага, сангуудтай компани хэрхэн хамтран ажиллах талаар гаргах шийдвэрийг батлах;
- салбар компани байгуулах шийдвэрийг батлах;
- компанийн удирдлага ба дотоод аудитын үйл ажиллагаа, төлөөлөн удирдах зөвлөлийн урамшууллын зарчмыг батлах;

- нэгдмэл сонирхолтой болон сонирхлыг өргөтгөх хэлцлийн журмыг батлах;
- төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг батлах.

3.1.4. Компани холбогдох хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаа мөн түүний үйл ажиллагаанаас үүдэн гарах асуудлуудыг тодорхойлон зохицуулах хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хурлаар батална. Хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, хурлыг зохион байгуулах, зарлах, хуралдуулах, санал өгөх, шийдвэр гаргах үйл ажиллагааны талаарх зохицуулалтыг тусгасан байна.

3.2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх

3.2.1. Хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахад үүний бэлтгэл ажиллагааг зохион байгуулах явдал чухал юм. Дээр дурдсан шаардлагуудыг хангаж ажиллахад дараах асуудлууд чухал:

- хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гаргах;
- цаг тутамд хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангах;
- хувьцаа эзэмшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг судалж танилцах нөхцөл бололцоогоор хангах.

3.2.2. Төлөөлөн удирдах зөвлөл энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллана:

- хувьцаа эзэмшигчдийн хөтөлбөрийг боловсруулан гаргах ба батлах;
- хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр, цаг, газрыг тодорхойлон тогтоох;
- хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн жагсаалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хүмүүсийн нэрсийн жагсаалтыг гаргах;
- хувьцаа эзэмшигчдэд хурлын зар хүргэх тухай журам гаргах;
- хувьцаа эзэмшигчдэд явуулах материалыг жагсаалтыг хөтөлбөрийн дагуу гарган материалыг хэвлэн бэлтгэх;
- хурлын хөтөлбөрийн дагуу санал өгөх журам болон саналын хуудсыг бэлтгэх;
- хувьцаа эзэмшигчдэд хурлын тов, хөтөлбөр болон холбогдох бусад материалуудыг хүргүүлэх.

3.2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг хурлын хөтөлбөрт тодорхой тусгаж өгсөн байх ёстой. Хөтөлбөр нь тодорхой бус жишээ нь “бусад”, “гэх мэтчилэн”, “өөр/төрөл бүрийн” гэдэг үгсийг хэрэглэхгүй байх нь зүйтэй.

3.2.4. Хувьцаа эзэмшигчдийг хурлаар хэлэлцэх асуудлын талаар тодорхой мэдээллүүдээр хангасан байх ба энэхүү мэдээллүүд нь тухай шийдвэрлэх асуудалтай танилцах боломжоор хангах хэмжээнд байна.

3.2.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг үр дүнтэй хуралдуулахад хувьцаа эзэмшигчдэд хурлын материалыг үргэн шуурхай цаг хугацаанд нь нэгэн зэрэг явуулан хүргүүлэх шаардлагатай тул тухайн хувьцаа эзэмшигчийн бүртгэлтэй е-мэйл хаяг эсвэл шуудан эсвэл компанийн ажилчдаар хүргүүлэх нь зүйтэй.

3.2.6. Компанийн саналын эрхтэй хувьцааны 5-аас доошгүй хувийг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хурлын хөтөлбөрийн хэлэлцэх асуудалд нэмэлт оруулах нөхцөл боломжоор хангагдана.

3.2.7. Хурлын хөтөлбөрт нэмэлт оруулах санал болон хэлэлцэх асуудалд оруулах саналыг ирүүлэх эцсийн хугацааг хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын дагуу тогтооно. Хувьцаа эзэмшигчдээс тогтоосон хугацаанд ирүүлсэн саналыг хэлэлцээд хөтөлбөрийг эцэслэн гаргана. Компани уг эцэслэн гаргасан хөтөлбөрийн төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах нөхцөл бололцоогоор хангаж ажиллана.

3.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах

3.2.1. Хувьцаа эзэмшигчдэд хамгийн тохиромжтой байх байр байршил ба цагийг сонгон хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хувьцаа

эзэмшигчид өөрсдийн ажлаас хөндийрөх нөхцөл үүсгэхгүй байхаар долоо хоногийн амралтын өдрүүдэд зохион байгуулж болох юм.

3.2.2.Хувьцаа эзэмшигчдийн хурал нь 10 цагаас эрт ба 20 цагаас оройтохгүйгээр хурлыг зохион байгуулж явуулна.

3.2.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж хуралдуулах асуудлыг төлөөлөн удирдах зөвлөл хариуцна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, хурлын нарын бичгийн дарга, санал тоолох комиссыг төлөөлөн удирдах зөвлөлөөс томилно.

3.2.4.Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын хөтөлбөрийг танилцуулснаар хурлыг эхлүүлнэ. Хурлын ирцийг бүртгэсэн байна. Дараа нь хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудлыг эхлүүлнэ.

3.2.5.Хурлын дарга оролцогчдод үг хэлэх бололцоогоор бүрэн хангах буюу хувьцаа эзэмшигчдийн хурал явуулах журам, зарчмыг чанд сахина. Хурлын дарга хурлын явцад гарах бүхий л зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэнэ.

3.2.6.Хурлын хөтөлбөрт тусгасан асуудал тус бүрийг томилогдсон илтгэгч танилцуулах ба танилцуулах болон асуулт тавих хугацааг тогтоосон байна. Дараа нь санал өгөх үйл ажиллагааг явуулна.

3.3.Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг батлах

3.3.1.Хувьцаа эзэмшигчдэд батлан гаргах шийдвэрийн агуулга тодорхой ойлгомжтой байх ёстой. Энэ нь хэлэлцэж буй асуудалд санааг өгөх үйл ажиллагаан д саад учруулахгүй бөгөөд асуудлыг буруу ойлгох, бие биенээ ойлгохгүй байх, буруу шийдвэр гаргах зэрэг нөхцөлд байдал үүсэхгүй юм.

3.3.2.Хувьцаа эзэмшигчид өөрсдийн саналыг өгөхдөө "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" гэсэн үгээр илэрхийлэх ба саналыг ил тод байдлаар эсвэл бичгээр авах гэсэн хэлбэрээр явуулж болно. Саналыг ил тод байдлаар өгөхдөө гар өргөх хэлбэрээр, бичгээр өгч байгаа тохиолдолд "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" гэсэн үгээр илэрхийлэгдсэн урьдчилан бэлтгэн гаргасан саналын хуудсыг бөглөж өгнө.

3.3.3.Санал хураалтын үр дүнг санал тоолох комисс явуулж гаргана.

3.3.4.Санал хураах саналын хуудас бүр дараах мэдээллийг тусгасан байна:

- компанийн нэр, хаяг;
- хурлын байр, байршил, өдөр, цаг;
- хурлын хөтөлбөр;
- хөтөлбөрт тусгагдсан асуудал бүрээр санал өгөх сонголт буюу "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" үгсийг ашиглана.

3.3.5.Хувьцаа эзэмшигч нь "зөвшөөрсөн", "татгалзсан", "түдгэлзсэн" аль нэгийг сонгон саналаа өгнө.

3.3.6.Хурлын хөтөлбөрт тусгагдаагүй асуудлаар шийдвэр гаргахдаа батлахгүй байж болно. Иймд хөтөлбөрт тусгагдсан асуудал бүрт хувьцаа эзэмшигчид санал өгөх нөхцөл байдлыг хангах үүднээс хурлын дарга хэлэлцэх шаардлагатай бүх асуудлыг хурлын хөтөлбөрт бүрэн гүйцэд тусгах асуудлыг хариуцаж ажиллана. Хэлэлцэж буй асуудал тус бүрээр санал хураалт явуулна. Хоёр буюу үүнээс олон асуудлыг хамтруулан санал хураалтыг явуулахыг хориглоно.

3.3.7.Хурлын шийдвэрийг компанийн хувьцаа эзэмшигчдэд хурдан шуурхай хүргүүлнэ.

3.3.8.Хувьцаа эзэмшигчид компанийн үрэмд санал өгөхөд тухайн хувьцаа эзэмшигч хуралд биеэр ирж чадахгүй тохиолдолд бичгээр саналаа өгөх ба ”зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” үгсийн аль нэгийг сонгон илэрхийлж өөрийн гарын үсгийг зурсан байна. Биеэр оролцож чадахгүй тохиолдолд хэрхэн санал өгөх талаар компанийн дүрэм эсвэл бусад холбогдох дүрмээр зохицуулан тусгасан байвал зохино.

3.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл

3.4.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрөөс доошгүй хоногийн дотор гарган хурлын даргын гарын үсэг, тамгаар баталгаажуулах ба түүнчлэн тэмдэглэл хөтөлсөн хурлын нарын бичгийн даргын гарын үсэг зурагдсан байна.

3.4.2.Хэрэв хувьцаа эзэмшигч хурал хуралдсанаас хойш ажлын 5 хоногийн дотор бичгээр хурлын тэмдэглэлтэй танилцах түүнд ирүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд түүнд тэмдэглэлийн хуулбарыг явуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

4.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг

4.1.1.Төлөөлөн удирдах зөвлөл компанийн үйл ажиллагаанд хяналт тавьжүр дүнтэй удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллана.

4.1.2.Төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн өрөнгө оруулалтыг хамгаалах, тэдгээрийн хувьцааны эзэмшлийг нэмэгдэх, компанид үр ашигтай шийдвэр гаргах, компанийн үйл ажиллагааг хянах болон бодлого, стратегийг тодорхойлох зэргээр үүргээ хэрэгжүүлж ажиллана. Төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих асуудалд анхаарлаа хандуулан менежментийн багийг стратегийн удирдамж болон зөвлөмжөөр хангаж ажиллах ба ялангуяа дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлт, хууль журмын хэрэгжилт, гол гол хэлцлүүд, нэгдэж нийлэх болон нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл зэрэгт хяналт тавина.

4.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх ба түүний бүтэц

4.2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийг компанийн үйл ажиллагаанд хяналт тавих болон үр дүнтэй засаглалыг бий болгох бүтэцтэй байхаар байгуулна . Компанийн зорилго, зорилтыг амжилттай хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах хувь хүн болон аудит эсвэл нягтлан бодох, санхүү эсвэл хуулийн чиглэлээр мэргэшсэн ба өндөр туршлагатай хувь хүнийг төлөөлөн удирдах зөвлөлд сонгон ажиллуулна.

4.2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо сондгой байхаар бүтцийг бүрдүүлэх нь зүйтэй. Энэ нь зөвлөлийн үр дүнтэй үйл ажиллагааг дэмжиж ажиллах болон нөхцөл байдлыг өргөн цар хүрээтэй харж дүгнэлт гаргаж түүнийгээ үндэслэн оновчтой шийдвэр гаргах чадвар бүхий төлөөлөн удирдах зөвлөлийг бий болгох бөгөөд үүнтэй уялдуулан гишүүдийн тоог тогтооно.

4.2.3. Төлөөлөн удирдах зөвлөл нь хараат бус гишүүдтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн гэж дараах нөхцөлийг хангасан гишүүнийг хэлнэ. Үүнд:

- өмнө нь тус компанид ажиллаж байгаагүй эсвэл сүүлийн 5 жил д нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй;
- компани эсвэл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн зөвлөх үйл ажиллагаа явуулдаггүй;
- компани эсвэл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ханган нийлүүлэгч ба харилцагч бус;
- компани эсвэл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй үйлчилгээ үзүүлэх гэрээг хувиараа хийгээгүй;
- компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын гишүүн, дотоод аудит эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдтэй ойрын хамаатан бус;
- компанийн хувьцаа эзэмшигч эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан бус.

4.2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг боломжтой бол хараат бус гишүүнээр сонгох нь зүйтэй.

4.2.5. Хараат бус гишүүдийн тоо нь компанийн шийдвэр гаргахад өшөөлөх бололцоо бүхий зөвлөлийн бусад гишүүдийн тоотой тэнцвэртэй харьцаатай байх нь чухал. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах мэргэжлийн өндөр ур чадвар, туршлагатай байх гэх мэт шаардлагуудыг зөвлөл эсвэл компанийн дүрэмд тодорхойлж заасан байх нь зүйтэй.

4.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн үүрэг

4.3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, компанийн үр ашгийг нэмэгдүүлэх болон хувьцаа эзэмшигчид ба компанид үнэнч, шударга байх үүргийг үлгэрэн э. Ялангуяа зөвлөлийн гишүүд өөрсдийн эрх үүргээ хэрэгжүүлэхдээ дараах шаардлагуудыг хангаж ажиллана:

- Холбогдох хууль, компанийн дүрэм, журам болон бусад холбогдох баримт бичигт заасан үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхдээ компанийн эрх ашгийг дээдэлнэ.
- Хууль, компанийн дүрэм болон бусад холбогдох баримт бичигт заасан эрх мэдлийн хүрээнд үүргээ хэрэгжүүлнэ.
- Компанийн үйл ажиллагаанд хяналт тавих, эрх бүхий ажилтан нарын хэлэлцүүлэгт идэвхтэй оролцох ба хэлэлцэж буй асуудлыг үүрэгт шаардлагатай мэдээ мэдээллийг олж авахад хичээлүтгэл гаргаж ажиллана. Зөвлөлийн гишүүд зөвлөлийн хурлын өмнө ирүүлсэн материалтай урьдчилан танилцсан байх ба ялангуяа төлбөрт заасан хэлэлцэх асуудлууд болон санхүүгийн баримт материалтай илүү нарийн танилцсан байна.
- Компанийн үүгээс хангаж буй мэдээ мэдээллээс гадна бие дааж судалгаа шинжилгээ хийх болон гадны мэргэжлийн шинжээч урих зэргээр идэвх чармайлт гаргаж ажиллана.
- Компанийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа хувийг ашиг сонирхолтой хольж хутгахаас зайлсхийх бөөрийн эрх мэдлээ ашиглан хувьдаа ашиг олохыг хориглоно.
- Компанийн аливаа нууцын түвшний мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох хүртэл чандлан нууцална.
- Өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ өндөр ур чадвар, хичээл зүтгэл гарган ажиллана.

4.3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүр аливаа чухал шийдвэр гаргахдаа цаг тухайд нь шаардлагатай бүхий л мэдээ мэдээллээр хангагдах ёстой.

Дээрх үйл ажиллагааны хүрээнд гишүүд үүргээ хэрэгжүүлэх боломжийг хангах үүднээс компани тухайн асуудалтай холбоотой эрх бүхий албан тушаалтан буюу захирлуудад үүрэг өгөх эрхийг зөвлөлийн журам, стандартад зааж өгч болно.

4.4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх

4.4.1.Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох журам нь ил тод нээлттэй байх ёстой. Хувьцаа эзэмшигчид зөвлөлийн гишүүдэд нэр д эвшигчийн нэрийг дэвшүүлэх нөхцөл боломжоор хангагдсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг жижиг хувьцаа эзэмшигчид сонгон томилох нөхцөл боломжийг хангахүүднээс кумулятив санал эрхээр сонгуулийг явуулна.

4.4.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгуулийн хугацаа жил эсвэл 3 жил байж болно.

4.5.Төлөөлөн удирдах зөвлөлийн хороод

4.5.1.Олон улсын сайн туршлагаас үзэхэд компани засаглалын үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс төлөөлөн удирдах зөвлөл хороодтой байдаг. Тэдгээр хороод шийдвэр гаргахүйл ажиллагааг дэмжихүүднээс санал боловсруулах болон тусгай зорилтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий байна. Компанийн үндсэн чиглэл үйл ажиллагааны хэлбэрээс шалтгаалан тэдгээр хороод нь бусад үйл ажиллагааны функцийг хэрэгжүүлдэг байж болно.

4.5.2.Тухайн хороо нь тухайн үйл ажиллагааг явуулах өндөр ур чадвар бүхий мэргэжлийн, туршлагатай 3-аас доошгүй гишүүдтэй байх шаардлагатай. Компани нь дара ах хороодтой байж болно:

- нэр дэвшүүлэх;
- цалин урамшууллын хороо;
- аудитын хороо;
- эрсдэлийн удирдлагын хороо (энэхүү хорооны үйл ажиллагаа нь аудитын хорооны үйл ажиллагаатай хамт байж болно).

4.5.3. Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байх нь зүйтэй.

4.5.4. Хороодын гишүүд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс өөр хүн байж болно. Гагцхүү тэдгээр нь тухайн хорооны дийлэнх нь байж болохгүй.

4.6.Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороо

4.6.1.Цалин урамшууллын хорооны үйл ажиллагаа нь компанийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж үүргээ хэрэгжүүлэх явдлыг дэмжих болон зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлдэг байна. Компани захирлуудын цалин урамшууллын асуудлыг зохицуулах бодлогыг батлах төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн урамшууллын асуудлыг авч үзэх ёстой. Цалин урамшууллын хэлбэрээр тооцож болох боловч энэ нь хязгаартай байх ба дараах хэлбэрээр байж болно:

- тогтмол цалин;
- хуралд ирсэн тохиолдол бүрд;
- хурал даргалах цалин;
- төлөөлөн удирдах зөвлөлийг удирдах цалин;
- компанийн жилийн үр дүнг үндэслэн нэг удаа олгох цалин;
- хорооны үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд олгох цалин;

Компанийн үйл ажиллагааны хэлбэр ба бусад нөхцөл байдлаас шалтгаалан өөр бусад урамшууллын хэлбэрийг авч үзэж болох юм.

4.6.2. Төлөөлөн удирдах зөвлөлийг үнэлж дүгнэх системтэй байх нь зүйтэй.

4.7. Аудитын хороо

4.7.1.Аудитын хороо дараах үйл ажиллагаанд хяналт тавьж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, компанийн удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна:

- компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаанд тавьж буй хяналтын үйл ажиллагаа;
- дотоод хяналтын системийн хэвийнүйл ажиллагаанд тавьж буй хяналтын үйл ажиллагаа;
- аудитын үйл ажиллагаанд тавьж буй хяналтын үйл ажиллагаа;
- холбогдох хууль, дүрэм, журмын хэ рэгжилтэд тавьж буй хяналтынүйл ажиллагаанд хяналт тавих;
- компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих.

4.7.2.Аудитын хороо нь хөндлөнгийн аудиторыг сонгож ТУЗ-д танилцуулна.

4.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сонирхлын зөрчил ба нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцлүүд

4.8.1.Компани нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл ба сонирхлын зөрчлийг зохицуулах бодлоготой байна. Түүнчлэн төлөөлөн удирдах зөвлөлийн ёс зүйн кодексыг батлан мөрдөнө.

4.8.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн хувийн болон санхүүгийн сонирхлын зөрчил эсвэл компанийн эрх ашгийг нэн тэрүүнд тавих үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд үүсэх зөрчлийн үед сонирхлын зөрчил илэрдэг.

4.8.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь шийдвэр гаргаж буй асуудалд нэгдмэл сонирхолтой этгээд болох эсвэл сонирхлын зөрчил тэй бол энэ тухайгаар өвлөлд мэдэгдэж тухайн асуудалд саналөгөхгүй. Төлөөлөн удирдах зөвлөл их хэмжээний сонирхлын зөрчилтэй хэлцэл эсвэл нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцүүдийг баталж байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчид болон нийтэд мэдээлж ил тод болгосон байх ёстой.

4.9.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үүрэг

4.9.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараах үүрэгтэй байж болно.

- компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;
- бүрэн эрхийнхээ хүрээнд компанийн ажилтнууд компанийн засаглалын бодлогыг дагаж мөрдөх;
- компанид сайн засаглалын практикийг хэвшүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх арга хэмжээ авах;
- хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах арга хэмжээг зохион байгуулах;
- мэдээллийг нийтэд хүргэх арга хэмжээ авах замаар компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
- хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас төлөөлөн удирдах зөвлөлд ирүүлсэн аливаа санал, гомдол хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох;
- компани доторх маргааныг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах.

ТАВДУГААР БҮЛЭГ. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

5.1. Гүйцэтгэх удирдлагын эрх

5.1.1. Гүйцэтгэх удирдлага компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулна. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд удирдамж зөвлөмж өгч удирдлагаар хангахын тулд гүйцэтгэх удирдлага болон менежментийн баг байна.

5.1.2. Менежментийн багийн эрх мэдэлд хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх ба төлөөлөн удирдах өвлөлийн эрхийн хүрээнд шийдэгдэхээс бусад компанийн менежментийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой бүх асуудлууд орно. Компани менежментийн багийн эрхтэй холбоотой асуудлуудыг хуулийн хүрээнд дүрэм болон гэрээнд тусгасан байна.

5.2. Гүйцэтгэх удирдлагын гишүүдийн цалин урамшуулал

5.2.1. Компаниас менежментийн багын гишүүдийн авах цалин урамшууллын систем нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигтай нийцсэн байна. Компани тухайн гүйцэтгэх удирдлагуудын цалин, урамшууллын системийг нэвтрүүлж ажиллана.

5.2.2. Удирдлагын багийн цалин урамшууллыг урт хугацааны туршид авахаар тодорхойлон тогтоох ба үүнийгээ компанийн дүрэм, гэрээнд тусгасан байна. Төлөөлөн удирдах зөвлөлөөс менежментийн багийн үнэлгээний системийг боловсруулан гаргасан байна.

5.3. Менежментийн багийн гишүүдийн сонирхлын зөрчил ба нэгдмэл сонирхолтой этгээдийн хэлцэл

5.3.1. Төлөөлөн удирдах зөвлөлтэй ижил сонирхлын зөрчилтэй эсвэл нэгдмэл сонирхолтой этгээд болох тохиолдолд энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн хурал ба төлөөлөн удирдах зөвлөлд хурлын тухайн асуудалд санал өгөхгүй болохоо мэдэгдэнэ.

5.3.2. Хувьцаа эзэмшигчдийн үйл хурал удирдлагын багын хэлцлүүдийг/сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаар шийдвэр гаргах үүнчлэн тухайн хэлцлүүдийг нээлттэй болгох гэх мэт/ зохицуулсан үйл ажиллагааны зарчмыг батална.

ЗУР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

6.1. Санхүүгийн тайлагнал

Санхүүгийн тайлагналын үндсэн зорилго бол компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд компанийн хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх явдлыг хангах явдал. Компани тайлагналыг үйл ажиллагаандаа олон улсын санхүүгийн тайлагналын стандартыг мөрдөн орчин үеийн санхүүгийн тайлагналын системд хүргэж ажиллана. Түүнчлэн компани найдвартай санхүүгийн тайлагналын системийг бий болгохын тулд дараах шаардлагуудыг мөрдөнө:

- санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хуулийн баримт бичгүүдийг баталж мөрдөх;
- дотоод хяналтын системийг бий болгох;
- компанийн эрсдэлийн системийг бий болгох;
- компанийн гүйцэтгэх ажилтан нарын хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх;
- компанийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдал, найдвартай байдлыг хангах.

6.2.Хөндлөнгийн аудит

6.2.1.Хөндлөнгийн аудитор нь сонирхлыг өөрчлөөс хол байх ба үүргээ сайн хэрэгжүүлэхийн тулд бие даасан хараат бус, мэргэжлийн өндөр ур чадвартай байна.

6.2.2.Хөндлөнгийн аудитор зөвхөн аудитын санал зөвлөмжөөр хангах ба аудитын бус үйлчилгээг компанид үзүүлдэггүй байна. Хөндлөнгийн аудитор нь олон улсын аудитын стандартын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

6.2.3.Хөндлөнгийн аудиторыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилдог байна. Компани хөндлөнгийн аудитыг томилох үйл ажиллагааг зохицуулсан дотоод журамтай байна.

6.2.4.Компанийн аудитынүйл ажиллагааг явуулах хөндлөнгийн аудитын компанийн аудиторыг 3 жилийн хугацаатай сонгон ажиллуулна.

6.3.Мэдээллийн ил тод нээлттэй байдал

6.3.1.Төлөөлөн удирдах эвлөл компанийн үйл ажиллагааны холбогдох бүх мэдээллээр цаг тухай бүр, бүрэн, ил тод хангах удирдамж зааврыг батална.

6.3.2.Компани зөвхөн хуулийн шаардлагыг хангах бус мөн олон улсын сайн туршлагын дагуу бизнесийн тодорхойлолт, санхүүгийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн өөрчлөлт, бэлэн мөнгөний урсгал болон аливаа материаллаг эрсдэлүүд ба эрсдэлийн хүчин зүйлсийг нээлттэй болгосон мэдээллүүдийг жилийн тайландаа тусгасан байна.

6.3.3.Компани болсонүй явдал боло н дунд хугацааны ү р дү нг ил то д мэдээлнэ. Компани өөрийн вэб сайтаар дамжуулан мэдээллийг ил тод байлгах ба өөрсдийн жилийн тайланг албан ёсны сайт дээр байршуулан мэдээлнэ.

6.3.4.Компанийн мэдээллийн ил тод байдлын бодлогыг тодорхойлж нийтэд мэдээлж ил тод болгоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ДОТООД ХЯНАЛТЫН СИСТЕМ БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

7.1. Дотоод хяналтын систем ба дотоод аудитын үйл ажиллагаа

7.1.1.Компани мэдээллийн ил тод нээлттэй байдал ба мэдэрлэлтийг баталгаажуулах дотоод хяналтын тогтолцоог бий болгосон байна.Төлөөлөн удирдах зөвлөл компанийн санхүүгийн зорилт ба хэрэгжилтийн үр дүнг баталгаажуулах дотоод хяналтын найдвартай системээр хангах ёстой.

7.1.2.Дотоод хяналтын систем нь компанийн удирдлагын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх болон компанийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэж түүний дагуу удирдамж заавраар газар хэлтсүүдийг хангадаг байна. Дотоод хяналт дараах асуудлыг авч үзнэ:

- санхүүгийн тайлан болон мэдээллийн системд хамаарагдах үйл ажиллагааг тодорхойлох гэх хяналт хийх орчинг тодорхойлох;
- компанийн эрсдэлийг үнэлэх үйл ажиллагаа;
- хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах;
- хяналтын үйл ажиллагаанд мониторинг хийх.

7.1.3.Компани дотоод хяналтын системийн нэг хэсэг болох дотоод аудитын газартай байна. Дотоод аудитын үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг удирдлага болгоно.

- санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн найдвартай байдал ба нэгдмэл байдал;
- үр ашигтай үйл ажиллагаа;
- хөрөнгө хамгаалалтын найдвартай байдал;
- хууль, компанийн бодлого ба дүрэм, журмын хэрэгжилт.

7.1.4.Дотоод аудитын газар байгууллагын бүхий л түвшний хяналт шалгалтын өргөн хүрээг хамрах ба удирдлагаас хараат бие даасан байна.

7.1.5.Монгол улсын хууль эрхүйн зохицуулалтын хүрээнд болон Дотоод аудиторын олон улсын институтын баталсан стандартын дагуу дотоод аудитын үйл ажиллагааг явуулна.

7.2. Эрсдэлийн удирдлага

7.2.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь гадаад ба дотоодүйл ажилла гааны үндсэн бүхий л эрсдэл, санхүү ба хуулийн хэрэгжилт болон бусад эрсдэлийг эрсдэлийн менежментээр хангах нэгдсэн үйл ажиллагааг хариуцна. Төлөөлөн удирдах зөвлөл нь гарах эрсдэлүүдийг тодорхойлж үнэлэн дүн шинжилгээ хийх болон түүний нөлөөллийг тодорхойлох зэрэгүйл ажиллагааг явуулах асуудлыг компани хариуцах болохыг баталгаажуулах ба тэдгээр эрсдэлийг бууруулах болон авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг батална.

7.2.2.Менежментийн баг эрсдэлийн удирдлагын журам, дүрмийг боловсруулан хэрэгжүүлж хэрэгжилтэд хяналт тавих асуудлыг хариуцна.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ОРОЛЦОГЧ ТАЛУУД

8.1.Компани оролцогч талуудын (ажилчид, зээлүүлэгчид, харилцагчид, ханган нийлүүлэгчид, орон нутгийн иргэд болон ард иргэд) эрхийг хүндэтгэнэ. Компани ажилчид, зээлүүлэгчид, ханган нийлүүлэгчдийн сонирхол болон байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудлуудыг тооцон шийдвэр гаргах ба тухайн гаргах гэж буй шийдвэрүүд нь бүх оролцогчдод нөлөөлөх эсэхийг тооцсоны үндсэн дээр тэд шийдвэрүүдээ гаргаж байх ёстой.

8.2.Компани оролцогч талуудыг компанийн төлөвлөгөө, тайланг гэх мэт мэдээллүүдтэй танилцах боломжоор хангасан байна.

8.3.Компани оролцогч талуудтай холбоотой хууль, дүрмийг мөрдөж ажиллах ба хууль, журамд заасан оролцогч талуудын эрх ашгийг зөрчсөн үйл ажиллагаа явуулахгүй.

8.4.Компани нь оролцогчид талуудын үр дүнтэй харилцаа холбоог хангахын тулд хууль болон олон улсын сайн туршлагын дагуу санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

8.5.Компани нь оролцогч талуудтай холбоотой эдийн засаг, нийгэм болон байгаль орчны (жишээ нь авилгын эсрэг бодлого, өмчийн бодлого, ханган нийлүүлэгчид ба харилцагчдын харилцаа холбоог зохицуулах бодлого, компанийн нийгмийн хариуцлагын бодлого, байгаль орчныг хамгаалах бодлого гэх мэт) асуудлуудын талаарх мэдээллийг ил тод мэдээлнэ.

8.6.Мэргэжлийн хөрөнгө оруулагчид өөрсдийн компанийн засаглал болон санал өгөх бодлого мөн түүнчлэн санал өгөх эрхээ хэрхэн хэрэгжүүлэх журмаа ил тод нээлттэй болгосон байна.

8.7.Мэргэжлийн хөрөнгө оруулагчид тэдний хөрөнгө оруулалттай холбогдон үүсэх эрхээ хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмаа ил тод нээлттэй болгосон байна.

8.8.Хувьцаа эзэмшигчид болон мэргэжлийн хувьцаа эзэмшигчид энэхүү кодекст заасан үндсэн эрхээ урвуулан /хэтрүүлж ашиглах, буруугаар ашиглах, зарчимд заасан эрхээ зөрчих/ ашиглаж үгсэн хуйвалдахаас бусад зорилготой бол өөр хоорондоо харилцан зөвлөлдөх боломжтой байна.